



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/66

Хажуу шинэ-Ус

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжих “Дэнжийн гудамжыг өнгөт гэрэлтүүлэгтэй болгох” худалдан авах ажлыг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн (Засаг даргын орлогч)

Гишүүд: Л.Батбаатар (4 дүгээр Багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Сувдмаа (Хөдөлмөр эрхлэлтийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Тендер шалгаруулалтыг хууль журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3.Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Сувдмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.АРИУНАА

482401066